



ЗӨВЛӨМЖ

#1. ЗӨВЛӨМЖ

Авлигатай тэмцэх газрын 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 1/3753 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжид дурдсан зөрчил, дутагдал дахин илэрч байгаад дүгнэлт хийх, зөвлөмжийг нэгмөр хэрэгжүүлж ажиллах

Нэг. Архангай аймаг нь Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.3-т "энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана", 3.1-т "Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна." гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал, Архангай аймгийн Хашаат сумын Засаг даргын нөөц хөрөнгийн тухайн жилийн төсвийн 17.2 хувийг хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаанд зарцуулсан. Тухайлбал, Архайнгай аймгийн Хашаат сумын уугуул, Эрдэнэбулган сумын Тамгын газрын дарга Б.Энхсайханд хүндэтгэл үзүүлэхэд 100.000 төгрөг, тамирчин С.Батцэцэгт хүндэтгэл үзүүлэхэд 250.000 төгрөг, генерал цол хүртсэн Б.Ганбаатарт хүндэтгэл үзүүлэхэд 150.000 төгрөг, аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасанд хүндэтгэл үзүүлэхэд 182.700 төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Мөнхбатад хүндэтгэл үзүүлж, мөнгө аяга авч өгөхөд 180.000 төгрөг, нийт 862.700 төгрөгийг зарцуулсан. Мөн Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин 2018 оны 08 дугаар сард Архангай аймагт нэг өдөр ажилласантай холбоотойгоор 3.226.030 төгрөгийг нөөц хөрөнгөөс тус тус зарцуулсан байна.

Хоёр. Архангай аймгийн хэмжээнд 2018 онд Эрдэнэбулган сумын 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Б.Энхжаргал, Хотонт сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Базаррагчаа нарын 2 албан тушаалтан томилогдсноосоо хойш 30 хоногийн дотор ХАСХОМ гаргаагүй, хугацаа хожимдуулж мэдүүлсэн нь хариуцлага хүлээлгэх үндэслэл тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2-т заасны дагуу хариуцлага тооцуулсан.

Гурав. Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд 2017 онд 7.636.999 төгрөгийг шүүхийн шийдвэрээр эргэн ажилдаа томилогдон ажиллаж байгаа 2 албан тушаалтанд олгосон байна. Дээрх 2 хүнд олгосон 7.636.999 төгрөгийн хохирлыг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ. Хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", мөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "...гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаагүй.

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам" баталсан. Гэтэл Архангай аймгийн Хотонт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 40 дүгээр тогтоолоор "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ыг давхардуулан баталсан. Цахир сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/02 дугаар тушаалаар 1995-2000 оны мал тооллогын бүртгэлээс лавлагаа гаргахад нэг оноос 2000 төгрөг гэж үнэ тарифыг тогтоохдоо Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Засгийн газраас тогтоосон бүтэц, орон тооны хязгаарт багтаан Тамгын газрын орон тоо, цалингийн санг тогтоож, ажилтнуудыг томилж, чөлөөлнө", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэсэн заалтуудыг үндэслэл болгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т "Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хувийн зүйл заалтыг тодорхой заана" гэж



#2. ЗӨВЛӨМЖ

- Архангай аймгийн Засаг даргын 2018 оны 08 дугаар сард А/460 дугаар захирамжаар 3.226.030 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарлагдсан хөрөнгийн санхүүгийн анхан шатны баримттай танилцахад 2018 оны 01 дүгээр сарын 24 ны өдрөөс 08 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацааны нийт 1.260.800 төгрөгийн 8 ширхэг зарлагын баримт байсан нь санхүүгийн анхан шатны баримтыг хуурамчаар үйлддэг гэсэн дүгнэлт хийхэд хүргэсэн болно.

Төсвийн хөрөнгө зарцуулсан санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв илэрхийлэн бүртгэж, тайлагнах

#3. ЗӨВЛӨМЖ

Орон нутагт томилолтоор ажиллаж буй төрийн албан хаагчдын албан зам хоног, байрны зардлыг Сангийн сайдын тушаалаар баталсан хэмжээгээр тухайн байгууллагаас олгосоор байхад тэдний байр, хоолны зардлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөс давхар гаргаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин 2018 оны 08 дугаар сард Архангай аймагт нэг өдөр ажилласантай холбоотойгоор Архангай аймгийн Засаг даргын А/460 дугаар захирамжаар 3.226.030 төгрөгийг бараа, гэр буудал, хоолонд, УИХ-ын гишүүд аймагт ажиллахад 6.525.974 төгрөг, Засгийн газар, Улсын онцгой комиссын ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллахад 1.552.320 төгрөгийн зардал тус тус гаргасан байна.



#4. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, 29.2 дахь хэсгийг үндэслэл болгон "Олон улс, тив, дэлхийн зэрэглэлийн тэмцээн, олимпийн наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчид урамшуулал олгох журам"-ыг баталж мөнгөн урамшуулалын хэмжээг 100.000-2.000.000 төгрөг байхаар тогтоон, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс тухай бүр гаргаж байхаар заасан нь Сангийн сайдын баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг зөрчсөн, мөн Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолоор баталсан "Олон улсын олимпийн хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам", "Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам"-тай давхардуулан журамласан.

Засгийн тогтоолоор журамтай байгаа Архангай аймгийн Засаг даргын 2018 оны А/218 дугаар захирамжаар "Олон улс, тив, дэлхийн зэрэглэлийн олимпийн амжилттай медаль тамирчин, дасгалжуулагчид урамшуулал журам"-ыг болгох	Газрын баталсан давхцаж Архангай аймгийн Засаг даргын 2018 оны А/218 дугаар захирамжаар "Олон улс, тив, дэлхийн тэмцээн, наадамд оролцож хүртсэн түүний оролцож хүртсэн түүний олгох хүчингүй болгох
---	---

#5. ЗӨВЛӨМЖ

Ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлахдаа "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг баримталж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд орон нутгийн давсан орлогын хөрөнгөөр "БЭБГ" ХХК-иас 49.900.000 төгрөгөөр Ланд Крузер 200 маркийн автомашин худалдан авсан. Гэтэл уг автомашин өмнө нь Архангай аймгийн Засаг даргын тамгын газарт ашиглагдаж байгаад актлагдан, 2017 онд "БЭБГ" ХХК дуудлага худалдаагаар 40.200.000 төгрөгөөр худалдан авсан байсан.



2018 онд аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангаас 143 иргэнд 1.399.900,000 төгрөгийн зээл олгосон. 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 1623 иргэнд 6.698.000.000 төгрөгийн зээл олгож, үүнээс 1251 иргэний 3.984.000.000 зээл хэвийн, 871 иргэний 3.104.000.000 төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 660 иргэний 2.124.000.000 төгрөгийн зээл чанаргүй байхад аймгийн хэмжээнд 319 иргэний 1.597.000.000 төгрөгийн зээлийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээс өөр арга хэмжээ аваагүй байна.

#6. ЗӨВЛӨМЖ

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, эрсдлийг бууруулж, үр өгөөжийг сайжруулахад эрх бүхий албан тушаалтнууд анхаарч, хяналтыг сайжруулах

#7. ЗӨВЛӨМЖ

Орон нутгийн хөгжлийн хөрөнгөөр санхүүжиж буй ажил, үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэхгүй, зорилтот бүлгийн эрэлт, хэрэгцээг хангахуйц байдлаар, аймгийн иргэдийн оролцоотой

2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажлыг иргэдээс санал авч эрэмблэх ажлыг зохион байгуулаагүй Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн.



Тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болж, шууд гэрээ байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулсан байх бөгөөд тендерт оролцсон аж ахуй нэгжүүдийг үл ялих шалтгаанаар хасах улмаар Засаг даргын Тамгын газрын удирдах албан тушаалтнууд болон өөрсдийн буюу хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийг шууд сонгох явдал нь түгээмэл болсон байна. Тухайлбал.

- Аймгийн Мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн халаалтын тогооны шинэчлэл, засварын ажлын тендерт “БГБС” ХХК буюу Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын газрын дарга П.Энхтайваны хамаарал бүхий компанитай гэрээ байгуулсан.

- Байгаль орчны хяналтын багаж, машин техник, хэрэгсэл нийлүүлэх тендерт “Тамирын цахиур” ХХК буюу Эрдэнбулган сумын Засаг дарга Ж.Гурвантамирын хамаарал бүхий компанитай гэрээ байгуулсан.

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын “Шивэрт” дэх амралтын газрын хоол, хүнс нийлүүлэх тендерт “Гострейд” ХХК буюу аймгийн ИТХ-ын төлөөлөгч Ш.Лхагваагийн хамаарал бүхий компанитай гэрээ байгуулсан.

Мөн нийт худалдан авах ажиллагааны материалуудтай танилцах явцад илэрсэн зөрчлийн талаар дурдвал:

- Тендерийн баримт бичиг дутуу ирүүлсэн аж ахуйн нэгж тендерт сонгон шалгаруулсан;
- Аж ахуйн нэгж тендерт сонгон шалгарсаны дараа гэрээний гүйцэтгэлээ түншлэл нэрийн дор өөр аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлдэг;
- Тоног төхөөрөмж, барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэхэд ажиллах хүч дутмаг, инженер техникийн ажилтангүй аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулдаг;
- Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл, тайлбар гаргадаггүй;
- Тендерийн баталгааны шаардлага хангаагүй аж ахуйн нэгж сонгон шалгаруулдаг;
- Татварын өртэй аж ахуйн нэгж сонгон шалгаруулсан;
- Үндэслэлгүйгээр шууд гэрээ байгуулж ажил өгдөг зэрэг.

Орон нутагт үнэлгээний хороонд ажиллах эрх бүхий сертификаттай хүн дутмаг, гэрээний биелэлтэд хяналт тавьдаггүй, гэрээ дүгнэдэггүйгээс үүдэн тендерийн гүйцэтгэл чанаргүй болж байна.

#8. ЗӨВЛӨМЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг буруу хэрэглэх, тендерийг нэр төдий зохион байгуулах, ашиг сонирхлын илт зөрчилтэй компанийг сонгон шалгаруулж байгаад дүгнэлт хииж, зөрчлийг арилгах, хариуцлага хүлээлгэх, таслан зогсоох хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх

**#7. ЗӨВЛӨМЖ**

Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн.

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасныг мөрдөж ажиллах шаардлагатай.

<https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778>-ээс татаж үзэх.